

Сэдэв 1: Нягтлан бодох бүртгэл

П.Жаргалтуяа /Доктор(Ph.D.), профессор/



Давтах сэдэв

Агуулга:

1. Нягтлан бодох бүртгэлийн төрөл, агуулга, мэдээлэл хэрэглэгчид
2. НББ-ийн үндсэн зарчим, бүртгэлийн суурь
3. Дансны давхар бичилтийн систем, дансны ангилал, кодчилал
4. ААН-үүд санхүүгийн тайлангаа үнэн зөв тайлагнах үүрэг, ач холбогдол
5. Санхүүгийн тайлан бэлтгэх. Дасгал ажил
6. ААНОАТ-ын тухай хууль/шинэчилсэн найруулга/

1. Нягтлан бодох бүртгэлийн төрөл, агуулга

- Санхүүгийн бүртгэл /**Financial accounting**/ гадаад дотоод мэдээлэл хэрэглэгчдэд зориулагдана.
- Зардлын бүртгэл /**Cost accounting**/ Дотоод мэдээлэл хэрэглэгчдэд зориулагдана.
- Удирдлагын бүртгэл /**Managerial accounting**/ Дотоод мэдээлэл хэрэглэгчдэд зориулагдана.
- Татварын бүртгэл /**Tax accounting**/ Гадаад мэдээлэл хэрэглэгчдэд зориулагдана.

1. Санхүүгийн бүртгэлийн мэдээлэл, хэрэглэгчид

Мэдээлэл хэрэглэгчдийг 2 ангилна.

- **Гадаад мэдээлэл хэрэглэгчид:** Татварын байгууллага, нийгмийн даатгалын байгууллага, үнэт цаасны хороо, хөрөнгийн бирж, үйлдвэрчний эвлэл /Төрийн болон орон нутгийн байгууллага/, Хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчид /шууд харилцаатай байгууллага/ худалдан авагчид, нийлүүлэгчид, өрсөлдөгчид /шууд бус харилцаатай байгууллага/
- **Дотоод мэдээлэл хэрэглэгчид:** Удирдлага, менежерүүд, дотоод хяналтын ажилтан, дотоод аудиторунд, борлуулалтын ажилтан, бусад ажиллагсад

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчим

НББ-ийн үндсэн зарчмууд /НББ-ийн тухай хуулийн 5.1/

- **Байгууллагын бие даасан байх зарчим:** Аж ахуйн нэгж нь бие даасан хуулийн этгээд.
- **Мөнгөөр хэмжих зарчим:** НББ-ийн үзүүлэлтүүд зөвхөн мөнгөөр илэрхийлэгдэнэ.
- **Хоёр талт зарчим:** $\text{Хөрөнгө} = \text{Өр төлбөр} + \text{Эздийн өмч}$
- **Жинхэнэ хэрэгжилтийн зарчим:** Аливаа ажил гүйлгээг бодитой гарсан үед нь бүртгэнэ.
- **Материаллаг байх зарчим.** Материаллаг бус зүйлсийг тайлант хугацааны эцэст нийт дүнгээр бүртгэнэ. Тухайлбал: Хангамжийн материалын зарцуулалтын бүртгэл

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчим

НББ-ийн үндсэн зарчмууд /НББ-ийн тухай хуулийн 5.1/

- **Борлуулалтын зарчим:** Орлого олох үйл ажиллагаа явагдсан бол орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.
- **Уялдаат зарчим:** Орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн бол түүнтэй холбогдон гарах зардлыг уялдуулан бүртгэнэ.
- **Өртгийн зарчим:** НББ-д хөрөнгийг өртгөөр бүртгэнэ.
- **Тогтвортой байх зарчим:** Ажил гүйлгээг бүртгэх, тайлагнах аргууд ижил, тогтвортой байна.
- **Үнэн зөв байх зарчим:** Аливаа мэдээллийг зөв ангилж, үнэн зөв, бодитой үнэлж бүртгэнэ.

2. НББ-ийн үндсэн зарчим

- Аж ахуйн нэгжийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүсэхээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг **тасралтгүй байх зарчмаар гаргах;**
- Аж ахуйн нэгж нь мөнгөн гүйлгээний тайлангаас бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн **аккруэл сууриар бэлтгэх;**
- Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай **зэрэгцүүлэх боломжтой байх;**
- Санхүүгийн тайланд материаллаг дүнтэй зүйлсийг тусад нь харуулна. Материаллаг бус дүнтэй зүйлсийг шинж чанар буюу үүргийнх нь дагуу **ижил зүйлсийн дүнтэй нэгтгэн толилуулах;**

2. Нягтлан бодох бүртгэлийн суурь

6.1 Аж ахйун нэгж байгууллага НББ-ийг аккрузэл сууриар хөтөлнө.

НББ-д орлого, зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэх 2 суурь байна.

- **Нягтлан бодох бүртгэлийн аккрузэл суурь** гэж мөнгө хүлээн авсан, төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.
- **Нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь** нь мөнгө хүлээн авсан үед орлогыг, төлсөн үед зардлыг хүлээн зөвшөөрч бүртгэх арга юм.

3. Дансны давхар бичилтийн систем, дансны ангилал, кодчилал

- Хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчид гарсан өөрчлөлт бүрийг цаг тухайд нь бүртгэх хэрэгсэл дансыг НББ-д хэрэглэнэ. *Данс* гэдэг нь аж ахуйн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого, зардлын төрөл тус бүрээр ангилан бүртгэх, хадгалах бүртгэлийн хэрэгсэл юм.
- *Ажил гүйлгээ гэдэг* нь байгууллагын хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, үйл ажиллагааны үр дүнд өөрчлөлт оруулж буй үйлдэл юм. Байгууллагад өдөрт маш олон төрлийн ажил гүйлгээ гарч байдаг. Ажил гүйлгээ гарсныг анхан шатны баримтаар баталгаажуулах бөгөөд түүнд үндэслэн ажил гүйлгээг бүртгэдэг. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно.
- Ажил гүйлгээ болгоны дараа байгууллагын хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч, орлого, зардал, үйл ажиллагаанд өөрчлөлт гардаг ч санхүүгийн тайлан гаргах шаардлагагүй юм.

3. Дансны давхар бичилтийн систем, дансны ангилал, кодчилал

- Нэг ажил гүйлгээ 2 буюу түүнээс дээш дансанд бүртгэгдэнэ. Дансны давхар бичилт нь ажил гүйлгээг уялдаа, хамаарал бүхий нэг дансны дебетээс нөгөө дансны кредитэд ижил дүнгээр тусгах үйл явц юм. Дансны харилцаа гэдэг нь гарч байгаа ажил гүйлгээний агуулгаас хамаарч, данснуудын хооронд үүсэх харилцаа юм. Дансны харилцаа энгийн болон нийлмэл хэлбэртэй байж болно. НББ-д дансыг мөн чанараар нь:

1. Байнгын /тогтмол/ буюу санхүүгийн байдлын тайлангийн данс

2. Түр буюу орлогын дэлгэрэнгүй тайлангийн дансууд

3. Холимог данс: Урьдчилж гарсан зардал, урьдчилж олсон орлого

- **НББ-ийн үндсэн тэнцэл**

$$\text{Хөрөнгө} = \text{Өр төлбөр} + \text{Эздийн өмч}$$

3. Дансны давхар бичилтийн систем, дансны ангилал, кодчилал

Дансны кодчилал нь тухайн байгууллагын онцлогоос хамаарч хэдэн ч оронтой байж болно. Практикт 4, 6, 8 оронтой жагсаалт гол төлөв хэрэглэнэ. Аж ахуйн нэгжүүдэд НББ-ийн дансны үлгэрчилсэн зааварыг мөрддөг.

| Дансны ангилал, кодчилал | |
|----------------------------|--------|
| Мөнгөн хөрөнгө | 100101 |
| БХХО | 130101 |
| Авлага | 120401 |
| Бараа материал | 140101 |
| Хангамжийн зүйлс | 150310 |
| Үндсэн хөрөнгө | 200101 |
| Биет бус хөрөнгө | 210101 |
| Өглөг | 310101 |
| Эзэмшигчийн өмчийн дансууд | 410101 |
| Борлуулалт | 510101 |
| Өртөг /ББӨ/ | 610101 |
| Зардал | 700101 |
| Олз, гарз | 800101 |
| Татвар | 900101 |

Улс орон бүрт аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх НББ-ийн дансны үлгэрчилсэн заавар байдаг. Дансны жишиг, нэгдсэн жагсаалтад нийцүүлэн аж ахуй нэгж бүр үйл ажиллагааны онцлог, төрлийг харгалзан байгууллагадаа ашиглах дансны жагсаалтыг боловсруулан баталж, үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

4. ААН-үүд санхүүгийн тайлангаа үнэн зөв тайлагнах үүрэг, ач холбогдол

- НББ-ийн тухай хуулийн 18.1 заалтанд ААН-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа үнэн зөв тайлагнах үүрэг хүлээсэн байдаг.
- Үнэн зөв тайлагнах зарчим нь НББ-ийн нийтээр хүлээн зөвшөөрөгдөх зарчимд багтдаг.
- Гадаад, дотоод хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчтэй үр дүнтэй, нягт хамтран ажиллах
- Бизнес, үйл ажиллагааны эдийн засгийн үр дүнг үнэн зөв тооцох, бодит шийдвэр гаргах
- Бизнес, үйл ажиллагааны ирээдүйн чиглэл, хандлагыг зөв тодорхойлж, бизнес төлөвлөлтийг зөв хийх
- Бизнесийн нэр хүндээ өндөр байлгах, найдвартай харилцагч, түнш байх
- ААН-үүд нийгэмд чиглэсэн ажил, хүлээсэн үүргээ биелүүлэхэд чухал ач холбогдолтой.

5. Санхүүгийн тайлан бэлтгэх: Дасгал ажил, кэйс 1: “ААА” ХХК

“ААА” ХХК
Санхүүгийн байдлын тайлан
2012 оны 12 сарын 31

Мян.төг

| Хөрөнгө | Дүн | Эх үүсвэр | Дүн |
|------------------------------|-----------------|--------------------------|-----------------|
| Мөнгөн хөрөнгө | 40000.0 | Өр төлбөр | |
| Авлага | 50000.0 | Өглөг | 100000.0 |
| Бараа материал | 160000.0 | Цалингийн өглөг | 50000.0 |
| Эргэлтийн хөрөнгө | 250000.0 | Урт хугацаат банкны зээл | 200000.0 |
| | | Нийт өр төлбөр | 350000.0 |
| Барилга | 450000.0 | Эзэмшигчдийн өмч | |
| Тоног төхөөрөмж | 150000.0 | Энгийн хувьцаа | 250000.0 |
| | | Хуримтлагдсан ашиг | 250000.0 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 600000.0 | Эзэмшигчдийн өмч | 500000.0 |
| | | | |
| Нийт хөрөнгө | 850000.0 | Нийт эх үүсвэр | 850000.0 |

Орлогын дэлгэрэнгүй тайлан, ААА" ХХК,
2012 оны 12 сарын 31 өдөр

Мян.төг

| № | Үзүүлэлт | Тайлант үеийн дүн |
|----|---------------------------------------|-------------------|
| 1 | А. Орлого: | |
| 2 | Борлуулалтын орлого (цэвэр) | 800,000.0 |
| 3 | Борлуулалтын өртөг | (200,000.0) |
| 4 | Нийт ашиг(алдагдал) | 600,000.0 |
| 5 | Хүүний орлого | 200,000.0 |
| 6 | Нийт ашиг, орлогын дүн | 800,000.0 |
| 7 | Б. Зардал: | |
| 8 | Борлуулалт, маркетингийн зардал | 250,000.0 |
| 9 | Ерөнхий ба удирдлагын зардал | 150,000.0 |
| 10 | Санхүүгийн зардал | 80,000.0 |
| 11 | Бусад зардал | 140,000.0 |
| 12 | Үндсэн бус үйл ажиллаганы олз, (гарз) | |
| 13 | Нийт зардал | 620,000.0 |
| 14 | В.Ашиг | |
| 15 | Татварын өмнөх ашиг | 180,000.0 |
| 16 | Татвар (10%) | 18,000.0 |
| 17 | Татварын дараах цэвэр ашиг | 162,000.0 |

“AAA” ХХК
Өмчийн өөрчлөлтийн тайлан
 2012 оны 12 сарын 31 өдөр

мян.төг

| | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлти йн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдса н ашиг | Дүн |
|---|---------------------|------------------------------|--|---|---------------------------------|------------------------|-----------------|
| 2011 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 250000.0 | | | | | 188000.0 | 438000.0 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга | | | | | | | |
| Залруулсан үлдэгдэл | | | | | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | | | | | 162000.0 | 162000.0 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | | | | | |
| Зарласан ногдол ашиг | | | | | | (100000) | (100000) |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | | | | | | |
| 2012 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 250000.0 | | | | | 250000.0 | 500000.0 |

Мөнгөн гүйлгээний тайлан, “ААА” ХХК
2012 оны 12 сарын 31

Мян.төг

| Мөрийн № | Үзүүлэлт | Тайлант үеийн дүн |
|-------------|---|-------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | |
| | Бараа борлуулсан, үйлчилгээний орлого | 241,000.0 |
| | Ажиллагчдад төлсөн | (17,000.0) |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | (40000.0) |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | (15,000.0) |
| | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 169000.0 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | |
| | Барилга худалдаж авсан | (400000.0) |
| | Тоног төхөөрөмжөө худалдсан | 100000.0 |
| | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (300000.0) |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ: | |
| | Ногдол ашиг төлсөн | (100000.0) |
| | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (100000.0) |
| 4 | Валютын ханшны зөрүү | |
| 5 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (231000.0) |
| 6 | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 271000.0 |
| 7 | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 40,000.0 |

Санхүүгийн тайлангууд (хураангуй) “ ААА” компани

Баланс 2011 он 12 сар 31

мян.төг

| Хөрөнгө, эх үүсвэр | Дүн |
|-----------------------|---------------|
| Хөрөнгө | |
| Мөнгөн хөрөнгө | 271000 |
| Авлага | 67000 |
| Бараа материал | 120000 |
| Барилга | 50000 |
| Тоног төхөөрөмж | 250000 |
| Нийт хөрөнгө | 758000 |
| Эх үүсвэр | |
| Өглөг | 320000 |
| Энгийн хувьцаа | 250000 |
| Хуримтлагдсан ашиг | 188000 |
| Нийт ЭХ ҮҮСВЭР | 758000 |

Баланс 2012 оны 12 сарын 31

мян.төг

| Хөрөнгө, эх үүсвэр | Дүн |
|-----------------------|---------------|
| Хөрөнгө | |
| Мөнгөн хөрөнгө | 40000 |
| Авлага | 50000 |
| Бараа материал | 160000 |
| Барилга | 450000 |
| Тонон төхөөрөмж | 150000 |
| Нийт хөрөнгө | 850000 |
| Эх үүсвэр | |
| Өглөг | 350000 |
| Энгийн хувьцаа | 250000 |
| Хуримтлагдсан ашиг | 250000 |
| Нийт ЭХ ҮҮСВЭР | 850000 |

Орлогын тайлан (хураангуй)

2012 оны 12 сарын 31

мян.төг

| Үзүүлэлт | Тайлант үеийн дүн |
|----------------|-------------------|
| 1. Нийт орлого | 800000 |
| 2. Нийт зардал | 638000 |
| 3. ТДЦА | 162000 |

Өмчийн ӨӨРЧЛӨЛТИЙГ ТАЙЛАН(ХУРААНГУЙ)

2012 оны 12 сарын 31

мян.төг

| Эхний нэмэгдэл | Хувьцаат капитал | Хуримтлагдсан ашиг | Нийт өмч |
|--------------------------|------------------|--------------------|----------|
| | 250000 | 188000 | |
| Нэмэгдсэн | | | 438000 |
| Хасагдсан | | | |
| Тайлант үеийн цэвэр ашиг | | 162000 | 162000 |
| Ногдол ашиг | | (100000) | (100000) |
| Эцсийн үлдэгдэл | 250000 | 250000 | 500000 |

Мөнгөн гүйлгээний тайлан (хураангуй) 2012 он 12 сар 31

мян.төг

| Мөрийн № | Үзүүлэлт | Тайлант үеийн дүн |
|----------|----------------------------------|-------------------|
| | Бүх цэвэр мөнгөн гүйлгээний дүн | (231000) |
| | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 271000 |
| | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 40000 |

ЕРӨНХИЙ ЖУРНАЛ

Байгууллагын нэр

Журналын төрөл ЕЖ

Тайлант.....он.....сар

| № | Баримтын | | Гүйлгээний утга | Дүн | Дансны нэр, код | |
|---|-----------|--------|-----------------|-----|-----------------|--------|
| | сар, өдөр | дугаар | | | Дебет | Кредит |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

Хөтөлсөн нягтлан бодогч.....()

Хянасан ерөнхий (ахлах) нягтлан бодогч.....()

ЕРӨНХИЙ ДАНС

Байгууллагын нэр

Дансны нэр..... Дансны дугаар.....

Журналын төрөл ЕД-2

| Журналын төрөл, дугаар | Дансны нэр, код | | | | | | Дансны нэр, код | | | | | |
|------------------------------|-----------------|----|----------------|----|-----------------|----|-----------------|----|----------------|----|-----------------|----|
| | Эхний үлдэгдэл | | Гүйлгээний дүн | | Эцсийн үлдэгдэл | | Эхний үлдэгдэл | | Гүйлгээний дүн | | Эцсийн үлдэгдэл | |
| | Дт | Кт | Дт | Кт | Дт | Кт | Дт | Кт | Дт | Кт | Дт | Кт |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

Хөтөлсөн нягтлан бодогч.....()

Хянасан ерөнхий (ахлах) нягтлан бодогч()

3. ААНОАТ-ын тухай хууль/шинэчилсэн найруулга/ 2020 он 1 сар1 дагаж мөрдөнө

29.1. Өмнөх татварын жилийн тайлангаар баталгаажсан борлуулалтын нийт орлогын хэмжээ 50.0 сая төгрөгөөс бага бол тухайн албан татвар төлөгч тухайн татварын жилийн 3 дугаар улиралд багтаан хүсэлт гаргасныг харьяалах татварын алба бүртгэж авсан тохиолдолд дараагийн татварын жилээс эхлэн тухайн албан татвар төлөгчийн үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.

29.6. Энэ хуулийн 29.1-д заасны дагуу татварын албанд хүсэлт гаргаж бүртгүүлсэн албан татвар төлөгч Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгч болсон өдрөөс эхлэн хялбаршуулсан горимоос гарна.

3. ААНОАТ-ын нэмэлт өөрчлөлт

20.1. Энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасны дагуу тодорхойлоход 0-6 тэрбум төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 25 хувиар нэмж албан татвар ногдуулна.

20.2.7. Энэ хуулийн 20.1-д заасныг үл харгалзан энэ хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, энэ хуулийн 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар

25.1. Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хуваарийг үндэслэн харьяалах татварын алба тухайн татварын жилд энэ хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулан төлөх албан татварын сар, улирлын хуваарийг албан татвар төлөгчид хүргүүлнэ.

3. НӨАТ-ын тухай хууль, шинэчилсэн найруулга /2015/

5 дугаар зүйл. Албан татвар төлөгч, албан татвар суутган төлөгч

3.1. Хувь хүн, хуулийн этгээдийн Монгол Улсад импортоор оруулсан, эсхүл Монгол Улсаас экспортод гаргасан болон Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулахад энэ хууль үйлчилнэ

5.1. Бараа, ажил, үйлчилгээг аливаа хэлбэрээр борлуулахгүй, аж ахуйн үйл ажиллагааны бус, хувийн хэрэглээнд худалдан авч, импортоор оруулсан хувь хүнийг албан татвар төлөгч гэнэ.

/Энэ хэсэгт 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

5.2. Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна:

6.5. Хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь энэ хуулийн 5.2-т заасан орлогын 20 буюу түүнээс дээш хувьд хүрсэн бол албан татвар суутган төлөгчөөр сайн дураар бүртгүүлж болно.

12 дугаар зүйл. Албан татварын тэг /"0"/ хувь хэрэглэх

12.1. Экспортод гаргасан дараах бараа, ажил, үйлчилгээнд энэ хуулийн 11.2-т заасан хувиар албан татвар ногдуулна:

НӨАТ-ЫН ТООЦОО /Жишээ/

| Худалдан авалт (үйлчилгээндээ зориулсан) | Бараа, Үйлчилгээний ҮНЭ | НӨАТ | Төлсөн нийт дүн |
|--|-------------------------------|--------------|--------------------|
| Гоймон | 15,000 | 1,500 | 16,500 |
| Сонгино | 3,200 | 320 | 3,520 |
| Мах | 34,800 | 3,480 | 38,280 |
| Кола | 21,000 | 2,100 | 23,100 |
| | | | |
| Нийт | 74,000 | 7,400 | 81,400 |

| Борлуулалт (Үзүүлсэн үйлчилгээ) | Бараа үйлчилгээний ҮНЭ | 10% НӨАТ | Хүлээн авсан мөнгөний нийт дүн |
|---------------------------------------|------------------------------|--------------|--------------------------------------|
| Падаан 1 | 20,000 | 2,000 | 22,000 |
| Падаан 2 | 15,200 | 1,520 | 16,720 |
| Падаан 3 | 30,000 | 3,000 | 33,000 |
| Падаан 4 | 22,500 | 2,250 | 24,750 |
| Падаан 5 | 8,350 | 835 | 9,185 |
| Падаан 6 | 3,000 | 300 | 3,300 |
| | | | |
| Нийт | 99,050 | 9,905 | 108,955 |

Рестораны эрхлэгч борлуулалтандаа ногдуулсан НӨАТ болон худалдан авалтандаа төлсөн НӨАТ-ын

зөрүүг ТЕГ-т төлнө. $9,905 - 7,400 = 2,505$ улсын төсөвт төлнө.

Баярлалаа. 😊